

БАТЛАВ:

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР:

Б.НАРАНЦЭЦЭГ

8а ангийн анги дэвших шалгалтын материал

Хувилбар-А

Хугацаа:60 мин

2024.05.30

8а ангийн сурагч овогтой

БААВГАЙ БУУСАН НАМАР

Нэг намар Хэнтийн нурууны баавгайнууд бараг цөмөөрөө буугаад ирж билээ. Тэр бол 1988 он байсан юм байна. Баавгай уг нь ян сарьдгуудын гүнд балар тайгад шивээлэн амьдардаг амьтан. Ил гарч хүн малд харагдах нь бараг үгүй. Аймшигт махчин араатан. Тийм атлаа дан махаар хоолшдоггүй, заавал самар, жимс ургамлын гаралтай хоол тэжээл хольж иддэг онцлогтой. Ичээлэхийнхээ өмнө самраар өөрийгөө бордож хаанаас нь ч харсан халбаганасан амьтан болох ёстой. Гэтэл тэр жил хөвчид самар гарсангүй. Намар болж ургамал гандсанаар баавгай таргалах нэр байтугай турж эхэлжээ. Өлссөн баавгай элбэгээр нь улаан шоргоолжны үүр ухаж эхэлдэг байна. Шоргоолжинд альдегид хэмээх спирт бий. Тэрэнд нь согтсоор байгаад архины цагаан солио тусч хаашаа ч хамаагүй тэнэж юуг ч хамаагүй хийдэг.

Ийм баавгайг ард түмэн хорхойтсон баавгай гэж нэрлэдэг билээ. Баавгай ингэж хорхойтох үзэгдэл 1962,1971 онуудад мөн болж байсныг эрдэмтэд тэмдэглэж үлдээсэн байдаг. Үүнээс өмнөх жилүүдэд юу болж байсан нь манай орны хувьд бүрхэг.Гэвч энэ удаагийнх шиг айхавтар явдал урьд өмнө огт болж байгаагүй гэж нутгийн анчид толгой сэгсэрцгээдэгсэн. Хэнтийн их нуруу нь Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгийн нутгийг дамнан оршдог.Эндээс буусан баавгайнууд баруун тийш гэхэд Төв аймгийн Баянчандмань сумын нутаг хүртэл,70-80 км, өмнө чиглэлд Баян сумын нутаг төмөр замын 12 дугаар зөрлөг хүртэл 130 км, зүүн өмнө чиглэлд Хэнтий аймгийн Баянхутаг сумын Өгөөмөр бригадын нутаг хүртэл 200 гаруй км хол газар ил гарч гүйсэн байна.Тэд цагаан газар гарч ирээд эхэндээ айж балмагдан жигтэйхэн их давхидаг аж. Нэг ойгоос нөгөө ой руу гүйгээд орчихдог шигээ санана л даа. Дараа нь цөхөрнө, ядарна.

Бүүр сүүлдээ цагаандаа гардаг байна Айлын эзгүй гэр хадланчдын майхан ухаж, идэж уучихмаар юм байвал цөлмөж дуусгана. Адуу мал руу ч халддаг. Тэр жилийн баавгайн хорхойтолтыг шинжлэх ухааны академи сум бүрээр нарийн судалгаа гаргуулж хохирлыг тооцсон байдаг юм. Судалгаанаас харахад Батсүмбэрийн зөгий үржүүлгийн газар хамгийн их хохирол амсчээ. Хужирт, Моност тохойн 40 бүл зөгийг сүйтгэж хамаг балыг нь идэж дуусгасан байна. Мөн Естийн рашаан их хохиролтойд тооцогдоно. Бурхны том байшинг нь нурааж бурхан тахил идээ будааг нь ёстой будаа болгож дууссан билээ. Сүүлдээ рашаанчдын очдог замыг нь эзлэн авч, тав хоног гэр майхнаас нь гаргахгүй сахисан байдаг. Тэднийг анчид ирж аварчээ.

Бас нэг золгүй явдал болжээ. Хагийн хар нуурын эрэг дээр Майдар дарга очиж ан хийж байх зорилгоор нэгэн байшин бариулсан юм байна. Тэр байшинд нь Мөнгөнморьтын хорихоос оргосон нэгэн хоригдол амьдардаг байж. Нуурнаас загасаа бариад идчихнэ. Самар жимсхэнээр бас гэдсээ хуурчихна.Гэтэл нэг өдөр хорхойтсон баавгай хүрээд ирлээ. Оргодол ч байшиндаа зугтан орж хаалга үүдээ дангинатал түгжээд бүгчихэж. Нэг хонож, хоёр хонож, нөгөө баавгай явдаггүй, үүдийг нь сахиад хэвтээд байж. Хэд хоносныг бүү мэд. Хожим нь хоригдол байшиндаа, баавгай үүдэнд нь турж үхсэн байсныг түүгээр явж байсан аянчин гөрөөчин хүмүүс илрүүлсэн юм. Хоригдол бугын шор эвэр атгаастай үүд рүүгээ мөлхөж байсан чигтээ өөд болжээ. Баавгай бас урдаас нь архирсан байдалтай хатчихсан байж.

Хорхойтсон баавгай Улаанбаатар хүртэл тэнээд ирж билээ. Амгалангийн Материал техникийн хангамжийн баазын хашаанд, мөн Богд уулан дахь Төрхурахын үслэг ангийн аж ахуйн гал тогоо руу дайрч орж агнуулжээ. Бас Багануурын уурхайн тэслэх бодисын агуулахад баавгай орж иргэний хамгаалалтын бэлэн байдал зарлуулж байсан удаатай гэнэ. Хорхойтох үзэгдэл наймдугаар сарын дундаас арван нэгдүгээр сарын эхэн буюу бараг ичээнд орж дуусах үе хүртэл үргэлжилжээ. Олон зуун баавгай бууж ирсэн гэж үздэг бөгөөд харин ууландаа эргэж харьсан нь цөөхөн гэнэ. Хүмүүс ихэнхийг нь галзуурч, согтуурснаар нь далимдуулж агнаж устгаж арьс, өөх, доньт саврыг нь авч хоцорсон юм.

Баавгай хэнэггүй, зоригтой, бас нэрэлхүү. Нэрэлхүү нь бүүр хэт. Илт давамгай зэвсэглэсэн анчидтай тааралдлаа ч зугтана гэж байхгүй. "Нэрэнд муухай юм даа" гэх шиг өөдөөс нь алхаж байгаад шүршүүлчихдэг. Гэвч тэрхүү хүчит араатан эрүүл "согтуудаа" ганцхан могойноос л айна. Юун нэрэлхэх барих. Могой харагдвал ухаан зулаггүй зугтаж арилдаг. Тэрэлжийн эхний айлууд энэнийг нь мэддэг тул тэр жил гэрээ тойруулж баахан зурмал могой өлгөчихсөн байдаг байж билээ. Баавгай нохой шуугиулан дөхөж явснаа зурмал могойг хармагцаа ум хумгүй буцан цогьдог байсан юм байх.

1. Баавгай уулнаас буусан шалтгаан нь юу вэ? /2 оноо/

.....
.....

2. Баавгайг хэнэггүй, зоригтой, бас нэрэлхүү амьтан гэдгийг нотлох баримт өгүүлбэр 2-ыг бичнэ үү. /2 оноо/

.....
.....

3. Эхэд байгаа дараах үгийн утгыг тайлбарлана уу. /2 оноо/

Зөрлөг -
Балмагдах

4. 1988 онд Хэнтий нурууны баавгай бараг цөмөөрөө бууж ирсний үр дагаварт юу болсон бэ? 4 үр дагавар бичнэ үү. /2 оноо/

.....
.....
.....
.....

5. Дараах тулгуур бичиглэлд тохирох жишээ үг 2-ыг олж бичээд дүрмийг тайлбарлан бичээрэй. /2 оноо/

ГЭГ+Г=ГГЭГ

Жишээ 2 үг:,

Зөв бичих дүрэм нь:

.....
.....

6. Зохиолын өгүүлэгдэхүүний тодорхойлолтыг зөв нөхөөрэй. /5 оноо/

- А. Зохиолын үйл явдал өрнөх болсон шалтгааныг гэнэ.
- Б. Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл хурцдаж дээд цэгтээ хүрэхийг гэнэ
- В. зохиолын зөрчил тэмцэл туйлдаа хүрч улмаар хэрхэн шийдэгдэж буйг гэнэ.
- Г. Зохиолын өгүүлэгдэхүүний зөрчил үүсэх суурь дэвсгэр бүхий үйл явдлыг гэнэ.
- Д. Учир шалтгааныг олохын тул цааш үргэлжилж байгаа хэсгийг гэнэ.

7. Дараах монгол бичгээр бичсэн өгүүлбэрийг уншиж хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

1. Өмнөд хэсэгт байгаа үгсийг
 2. Өмнөд хэсэгт байгаа үгсийг
 3. Өмнөд хэсэгт байгаа үгсийг
 4. Өмнөд хэсэгт байгаа үгсийг
 5. Өмнөд хэсэгт байгаа үгсийг
 6. Өмнөд хэсэгт байгаа үгсийг

.....
.....
.....
.....
.....
.....

БАТЛАВ:

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР:

Б.НАРАНЦЭЦЭГ

8а ангийн анги дэвших шалгалтын материал

Хувилбар-Б

Хугацаа:60 мин

2024.05.30

8а ангийн сурагч овогтой

Говийн угалз салхи

Говь нутагт шороон шуурга удаан хугацаагаар үргэлжлэн шуурахыг монголчууд угалз түйрэн гэж нэрлэдэг. Энэ нь алхмын өмнөх газар харагдахгүй болтол нүүр нүдгүй элсээр шуурахыг хэлж байгаа юм. Монголд шороон шуурга олонтоо тохиож иргэд, байгууллагад хохирол учруулахаас гадна зарим үед гамшгийн хэмжээнд хүрч хүн амьтны амьдрах орчинд таагүй нөлөөлдөг. Шороон шуурганы улмаас мал бэлчээрлэхэд саад болох, мал хорогдох, цахилгааны болон харилцаа холбооны шугам тасрах, элсний нүүлтээс хот суурин, зам харгүй элсэнд дарагдах зэрэг олон сөрөг үр дагавартай. Хүчтэй шуурга хөрсний үржил шимт хэсгийг хийсгэх, хөрс элэгдэх, элс нүүх, цөлжилт ихсэхэд ч нөлөөлөхөөс гадна агаарын булингаршил ихэсч, цацрагийн балансад тодорхой өөрчлөлт оруулдаг байна.

Монголын тал нутагт дэгдсэн түйрэн буюу шар шороон шуурга Хятадын ихэнх нутгийг дайрч, Солонгосын хойг, Японд улмаар Номхон далайг гатлан Канад, Хойд Америкт ч хүрч, аж үйлдвэрийн бүсээс элдэв төрлийн хорт бодис хаман хаа сайгүй тараадаг байна. Шар шороон шуурга боссон газарт үзэгдэх орчин үгүйлэгдэж, амьсгалын зам, зүрх судасны өвчин ихэсдэг аж. Шороон шуурга өнгөрсөн зууны дундуур буюу 1950-иад оны үед жилд дунджаар таван удаа болдог байв. Харин өнөөдөр давтамж нь хэд дахин нэмэгдэж, зарим жил гуч гаруй удаа хийсэж байгаа. Шороон шуурганаар шороо, элсний том ширхэгтэй нь ойрхон хийсч, жижиг нарийн ширхэгтэй нь 1-3 км-ийн өндөрт дэгдэн хуй салхи хэлбэрээр хэдэн мянган км зам туулна. Төв Азид байгаль цаг уурын болон хүний нөлөөгөөр их хэмжээний газар цөлжсөн. Үүнд ган, хуурайшилт, уур амьсгалын дулаарал зэрэг байгалийн хүчин зүйл нөлөөлдөг ч хүний буруутай үйл ажиллагаанаас их зүйл шалтгаалдаг. Мал олноор өсгөх, уул уурхайн салбарт хоцрогдсон технологи хэрэглэх, гар аргаар алт олборлох нь хөрсний эвдрэлийн гол шалтгаан болдог.

Монголын говь шороон шуурганы нэг эх үүсвэр болдог. Ялангуяа хөрсний гадарга хуурай, сул хөрстэй, агаар мандалд салхины хурд их хаврын улиралд элбэг ажиглагддаг. Агаарт хөөрсөн шороо 5 км-т тархаж салхины доор байгаа орон руу шилжихдээ бүдүүн ширхгүүд нь ойр үлдэж нарийн ширхэгтэй нь зэргэлдээх орон руу зөөгдсөнөөр алсын барааны харагдац буурдаг. Заримдаа онгоцны нислэг саатна. Амьсгалын замаар орж, хүний эрүүл мэндэд ч нөлөөлдөг. Байгалийн үзэгдэл учир зогсоох аргагүй. Харин нөлөөллийг багасгах үүднээс урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулж, мэдээгээ олонд хүргэснээр урьдчилан сэргийлж болно.

Жил бүрийн өдийд байгалийн гамшиг болон зах зээлд эргэлддэг мөнгөний урсгалын хооронд сонин зүй тогтол ажиглагддаг. Хятадын ихэнх нутгаар дайрч, аж үйлдвэрийн бохирдлуудыг хамсаар далайн чанад дахь орнуудыг бүрхдэг говийн угалз салхинаас Азийн орнуудын зарим төрлийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний борлуулалт эрс сэргэдэг аж. Тухайлбал, өнгөрсөн онд Өмнөд Солонгосын агаар цэвэршүүлэгчийн зах зээлийн багтаамж нэг их наяд вон буюу 933 сая ам.долларт хүрсэн байна. Энэ нь 2013 онтой харьцуулахад 30 хувь өссөн үзүүлэлт юм. Цаашид энэ зах зээл жилд бараг 50 орчим хувиар тэлнэ хэмээн Korea Times сонин мэдээлжээ. Мөн тус улсын айлууд угаасан хувцсаа гадаа хатаахаас зайлсхийх болсноор хувцас хатаагчийн үйлдвэрлэл нэмэгдсэн. Жижиглэн худалдааны Lotte Hi-mart дэлгүүрийн хувцас хатаагчийн борлуулалт л гэхэд 2017 онд 1100 хувиар өсчээ. Үүнээс гадна амны хаалт 213, нүдний дусаагуур 380, вакумдсан агаар 383 хувиар өссөн үйлдвэрлэлт, борлуулалттай гээд агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалдаг иргэдийн идэвхийг эдийн засгийн утгаар илэрхийлэх өгөгдөл олон байна.

1. Хүний нөлөөнөөс болж цөлжилт, хөрсний эвдрэл үүсгэх гол шалтгаанаас 2-ыг түүн бичээрэй /2 оноо/

2. Монголын говиос боссон хуй салхи хөрш зэргэлдээ орнуудад ашигтай нөлөө үзүүлдэг болохыг тайлбарлан бичээрэй. /2 оноо/

3. Эхэд байгаа дараах үгийн утгыг тайлбарлана уу. /2 оноо/
Нүүр нүдгүй
Элэгдэх

4. I цогцолбороос угалз салхи ямар сөрөг үр дагавар үзүүлж болох 4 жишээ олж бичээрэй. /2 оноо/

5. Дараах тулгуур бичиглэлд тохирох жишээ үг 2-ыг олж бичээд, дүрмийг дэлгэрэнгүй тайлбарлан бичээрэй. /5 оноо/

ЭГ+ЭЭ=ГЭЭ

Жишээ 2 үг:

Зөв бичих дүрэм нь:

6. Зохиолын хэсгийг уншаад зохиолч болон зохиолын нэрийг нөхөн бичээрэй. /5 оноо/

Зохиолын хэсэг	Зохиолч	Зохиолын нэр
1939 оны намар говь нутагт суудлын ногоон машинтай цэргийн нэг дарга Нямаа өвгөн гэгчийнхийг эрэн очив...		
4 сарын 1-нд манай ангийнхан шог зураач Цайдам гуайтай уулзаж элгээ хөштөл инээлээ		
... урьд шөнө гэрийн хошлонг хутгаар тас огтолчихсон байна билээ гэж ...		
Хүрээ зах зээлийн газар хятад маягийн томхон дэлгүүрийн үүдэнд хөл үймээн ихтэй ажээ. ...		
Тээр нэгэн жилийн өнтэйг яана ...		

